

ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын баталсан удирдамж дагуу Дэмжлэгт хяналтын үйл ажиллагааг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, ахлах мэргэжилтэн Г.Батцэцэг, мэргэжилтэн Я.Бадамсүрэн, Б.Алтангэрэл нар эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа явуулж буй нийт 11 эрүүл мэндийн байгууллагын 17 багийн ахлагч нар, багийн эмч, мэргэжилтнүүдийг оролцуулан хийж гүйцэтгэсэн.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ, ХСҮТ, ЦТЭ, Өөжинмед, Юнимед, RMC, CLWH эмнэлгүүдийн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах багуудын 2025 оны үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг хийн тайланг нэгтгэн ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн хэрэгжилтийн газарт хүргүүлсэн.

Цаашид дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг төрөөс илүү дэмжих тал дээр бүх байгууллага санал нэгдсэн ба тухайн эмчилгээний зардлын тодорхой хэсгийг Эрүүл мэндийн даатгалд хамруулж өгөх хүсэлт гаргах.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн цалин хөлс, илүү цаг урамшууллын асуудлыг шийдэх болон мэргэжил дээшлүүлэх давтан сургалт зохион байгуулах
- Тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг идэвхжүүлэх нийт ард иргэдэд хүргэх нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Дархлаа дарангуйлах эмийн ханган нийлүүлэлтийн асуудлаар ЭМЯ, Эм ханган нийлүүлэгч байгууллага, Эрхтэн шилжүүлэн суулгах баг, Эмчлүүлэгч, Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба хамтарсан уулзалт зохион байгуулах
- Донор эмнэлгүүд болон тархины үхэл тодорхойлох үйл ажиллагаанд оролцож буй эмч нарт илүү цаг, урамшуулал, нэмэгдэл олгох талаарх заалтыг журамд тусгах
- Багуудаас гаргасан санал хүсэлтийг судлаж , шийдвэрлүүлэх тал дээр ЭМЯ болон холбогдох байгууллагатай хамтран ажиллах
- Эс, эд, хадгалах банк байгуулах асуудлыг шийдвэрлэх